**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

(2024 оны эхний хагас жилийн байдлаар)

| Д/д | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, youtube суваг ) мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр нийтэд хүргэнэ. | Тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудсыг ИНЕГ, түүний харьяа салбар нэгжүүдийн цахим хуудсанд байршуулж, баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх;<br><br>Түгээсэн тоо, давтамж, хандалтын тоо. | ИНЕГ, түүний харьяа салбар нэгжүүдийн цахим хуудсанд мэдээллийг байршуулж, баримтжуулан, үр дүнг ИНЕГ-т тайлагнасан байна. | Улирал бүр | ХШҮДАА ЗУХЭЗХ<br><br>ИНҮТ-ийн ХАХ<br><br>ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжүүд | 1.ИНЕГ-аас бэлтгэсэн “Авлигаас ангид байя” шторк https://www.mcaa.gov.mn/newsread/3083 2.АТГ-аас бэлтгэсэн “Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн явц” зурагт мэдээлэл https://www.mcaa.gov.mn/newsread/3166 https://ncac.mcaa.gov.mn/mn/news/post/103 3.АТГ-аас бэлтгэсэн “Авлигын эсрэг та юу хийж чадах вэ?” зурагт мэдээлэл https://www.mcaa.gov.mn/newsread/3086 4.АТГ-аас бэлтгэсэн “ХАСХОМ гаргадаг албан тушаалтнуудын анхааралд” зурагт мэдээлэл https://mcaa.gov.mn/newsread/3020 https://ncac.mcaa.gov.mn/mn/news/post/991 5.ИНЕГ-аас бэлтгэсэн “Авлигын эсрэг таны оролцоо юу вэ?” зурагт мэдээлэл https://mcaa.gov.mn/newsread/3085 6.ИНЕГ-аас бэлтгэсэн авлигын эсрэг шторк https://mcaa.gov.mn/newsread/3083 https://ncac.mcaa.gov.mn/mn/news/post/1031ИНЕГ, түүний харьяа салбар нэгжийн мэдээллийн самбарт “Иргэн та авлигын эсрэг юу хийж чадах вэ?”, “Авлигатай тэмцэх газарт хэрхэн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах вэ?”, “Өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлт” Нэгдье аяны хүрээнд гарсан “Авлига гэдэг нь зөвхөн бэлэн мөнгө солилцох үйлдэл биш”, “2.4 их наяд хэр их мөнгө вэ?” зэрэг зурагт хуудас байршуулан нийт ажилтнууд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан. | |
| | | 1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулна. | 2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх;<br><br>Үр дүнг тооцож, нотлох баримтыг хавсаргасан байх. | **Эхний хагас жилд:**<br>**1** арга хэмжээг ИНҮТ, түүний салбар, нэгжүүдийг хамруулан зохион байгуулж, тайлагнасан байна. | 4 сард | ИНҮТ-ийн ХНУГ ХХ | ИНЕГ, АТГ хамтран 2024.06.14-ний өдрийн 09:00 цагт ИНЕГ, түүний харьяа салбар нэгжийн ажилтнуудад Авлигын эсрэг үйл ажиллагаа сэдэвт сургалтыг зохион байгуулж, цахимаар нийт 81 хүн хамрагдсан. Уг сургалтыг АТГ-ын комиссар С.Амартүвшин сургалтыг бэлтгэн явуулсан. Нийт 81 хүн хамрагдсан байна.<br><br> | 100 |
| | | | | **Жилийн эцэст:**<br>1 арга хэмжээг ИНЕГ зохион байгуулж, тайлагнасан байна. | 10 сард | ХШҮДАА ЗУХЭЗХ | Хугацаа болоогүй | |
| | | 1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг ажиллуулна. | Байршуулсан мэдээллийн тоо | **Эхний хагас жилд**: 5<br><br>**Жилийн эцэст**:6 | Сар бүр | ХШҮДАА | Иргэний нисэхийн үндэсний төвийн мэдээллийн самбарын хууль, эрх зүй буланд Нэгдье аяны хүрээнд гарсан “110 - Авлига ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх утас” зурагт хуудсыг байршуулж ажилласан.<br>ИНЕГ, түүний харьяа салбар нэгжийн мэдээллийн самбарт<br>1. “Иргэн та авлигын эсрэг юу хийж чадах вэ?”,<br>2. “Авлигатай тэмцэх газарт хэрхэн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах вэ?”, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. “Өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлт”,<br>4. “Нэгдье” аяны хүрээнд гарсан “Авлига гэдэг нь зөвхөн бэлэн мөнгө солилцох үйлдэл биш”,<br>5. “2.4 их наяд хэр их мөнгө вэ?” зэрэг зурагт хуудас байршуулан нийт ажилтнууд болон иргэдэд мэдээллийг хүргэж ажилласан.<br><br><br><br><br> | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | <br><br><br> | |
| | | 1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим хэвлэмэл ном, гарын авлага, | -3-аас доошгүй сурталчилгаан ы материал боловсруулсан байх;<br><br>-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн | **Эхний хагас жилд**:<br>1 /зурагт хуудас/ 1 /шторк/<br><br>**Жилийн эцэст**:1/шторк/ | 4, 5, 9 сард | ИНҮТ-ийн ХАХ | Авлигаас ангид байцгаая" гэх 33 секундийн видео шторкийг https://www.mcaa.gov.mn/newsread/3083 цахим системийн мэдээ, мэдээлэл буланд 2024.03.26-ны өдөр байршуулж, нийт ажилтнуудад танилцуулсан. https://oldimcaa.mcaa.gov.mn/news/more/594 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | брошюр зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж, олон нийтэд хүргэнэ. | сүлжээ (фейсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг ) мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр нийтэд хүргэсэн байх;<br>- Сурталчилгааны материалдаа авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх | | | | | |
| 2. | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 2.1. Албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулна. | Сургалтад хамруулсан ажилтнуудын тоо<br><br>Зохион байгуулсан сургалтын тоо | **Эхний хагас жилд:** Гүйцэтгэлээр, 1<br><br>**Жилийн эцэст**: Гүйцэтгэлээр, 1 | I-IV улирал | ХШҮДАА ЗУХЭЗХ<br><br>ИНҮТ-ийн ХНУГ ХХ | ИНЕГ, АТГ хамтран 2024.06.14-ний өдрийн 09:00 цагт ИНЕГ, түүний харьяа салбар. нэгжийн ажилтнуудад Авлигын эсрэг үйл ажиллагаа сэдэвт сургалтыг зохион байгуулж уг сургалтад цахимаар нийт 81 ажилтан хамрагдсан.<br><br>Мөн ИНЕГ, Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороотой хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалт зохион байгууллаа. Уг сургалтад нийт 150 ажилтан танхимаар, орон нутгийн нисэх буудлын болон бусад алба, нэгжүүдийн 100 орчим ажилтан цахимаар хамрагдлаа. | |
| | | 2.2.НААХЗА-ны нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагчдад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг зохицуулах талаарх сургалт хийнэ. | Сургалтад хамруулсан ажилтнуудын тоо<br><br>Зохион байгуулсан сургалтын тоо | **Эхний хагас жилд:** 53; 1 | 4 сард | ХШҮДАА | Авлигатай тэмцэх газраас 2024.04.26-ны өдөр зохион байгуулсан сургалтад Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагууд болон нисэхийн аюулгүй ажиллагааны нийт 40 хяналтын байцаагч хамрагдсан. Уг сургалтад нийт 53 хүнийг хамруулах байсан боловч тус өдөр өвчтэй -1, гадуур ажилтай -3, гадаадад сургалттай -1, ээлжийн амралттай -1, дотоод сургалттай -1, чөлөө авсан -1, нийт 8 хүн уг сургалтад хамрагдаж чадаагүй бай-а. Эдгээр хүмүүсийн ажлын и-мэйл хаягаар сургалтын PPT-г АТГ-ын холбогдох ажилтнаас зөвшөөрөл авч, 2024.06.12-ны өдөр хүргүүлсэн болно. | 100 |
| | | 2.3.Тус байгууллагаас үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | **Эхний хагас жилд:** 1 | II улирал | НААХЗА | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.11.24-ний өдрийн А/299 дугаар тушаалаар ИНЕГ-аас НААХЗА-ны үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор 2023 онд ИНЕГ-ын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, Аюулгүй ажиллагааны дотоод хяналт, дүрмийн боловсруулалтын албыг байгуулсан. Тус албанаас үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд: НААХЗА-ны НСҮАХХ, ҮГХ-ийн үйл ажиллагаанд 2024.03.28-ны өдрөөс 2024.04.03-ны өдрийн хооронд дотоод хяналт шалгалт хийж, тайланг тус албанд хүргүүлсэн. Хяналт шалгалтын тайланд төрийн үйлчилгээний чанар хүртээмж, хууль | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тогтоомж дүрэм журмын хэрэгжилт, баримт бичиг албан хэрэг хөтлөлт, хувь хүн болон байгууллагуудын гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал, үнэмлэх гэрчилгээ олгосон, хугацааг сунгасан байдал, байцаагчийн дүгнэлт ба түүний дагуу авсан арга хэмжээ зэрэг үйл ажиллагаатай хамааралтай нийт 10 үл нийцэл илэрч 8 зөвлөмж тусгагдсан. Уг зөвлөмжийг хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. | |
| 3. | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авна. | - Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх;<br><br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх;<br><br>- Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тусгах;<br><br>- Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх;<br><br>- Тайланд нотлох баримтыг | Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байна.<br><br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байна.<br><br>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тусгана. | I-IV улирал | ЗУХЭЗХ<br><br>ИНҮТ-ийн ХНУГ<br>ХХ | Гадны аж ахуй, нэгж байгууллагуудтай байгуулах худалдах, худалдан авах гэрээний төслийн "Гэрээний эрх, үүрэг" гэсэн хэсэгт ""Авлигын эсрэг хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1.2-7.1.7 дахь хэсэгт заасан үйлдэл, эс үйлдэхүй гаргасан тохиолдолд удирдах албан тушаалтан болон удирдах дээд шатны байгууллага, хуулийн хариуцлага хүлээлгэхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэх заалт, мөн гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлуудыг тус тус тусгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хавсаргасан байх. | | | | | |
| | | 3.2.Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | -Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; | **Эхний хагас жилд:** Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байна. | 2-3 сард | ЗУХЭЗХ | Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг ИНЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/281 дүгээр тушаалаар тодорхойлж, баталсан бөгөөд уг тушаалын хэрэгжилтийг хангуулахаар нийт албан хаагчдад болон 2024.05.27-ны өдрийн 01/1142 дугаар албан бичгийг харьяа байгууллагуудад хүргүүлсэн. | 100 |
| | | | Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх. | ИНЕГ-ын олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд болон ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж буй байдалд олон нийтийн хяналтыг 2023 онд хэрэгжүүлсэн тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлсэн. | 2-5 сард | ЗУХЭЗХ ХҮШДАА<br>ИНҮТ-ийн ХОЗА | Иргэний нисэхийн ерөнхий газар нь Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. Уг төлөвлөгөөний 3-т Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох гэсэн заалтыг тусгасан бөгөөд уг ажлын хүрээнд Засгийн газрын 2019 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-д нийцүүлэн ИНЕГ-ын даргын тушаалаар "Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар нэгжийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэл"-ийг баталсан. Мөн 2023 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээлэл буюу | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагын цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийлгэж, хяналт тавиулахаар иргэн А.Арвинжаргалтай 2023.11.29-ний өдрийн 67/23 дугаар "Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулсан. Иргэн А.Арвинжаргал нь тус газрын үйл ажиллагаатай танилцан, зөвлөмж, дүгнэлтийг ирүүлсэн. Уг зөвлөмжийн дагуу заасан хугацаанд мэдээллийг нээлттэй байршуулан ажиллаж байна. | |
| | | | | **Жилийн эцэст:** Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх холбогдох этгээдийг шалгаруулах ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулах арга хэмжээ авсан байна. | 6-7 сард | ЗУХЭЗХ<br>ИНҮТ-ийн ХНУГ<br>ХХ<br>ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжүүд | Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг баталсан. Уг журмын дагуу ИНЕГ-ын даргын 2024.05.20-ны өдрийн А/281 дугаар тушаалаар "Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар нэгжийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэл"-ийг баталсан. Цаашид олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх холбогдох этгээдийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. | |
| | | | | Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байна. | 8-11 сард | | Хугацаа болоогүй. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 4.1.НААХЗА-наас олгож буй тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлнэ. | Тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлсэн байх. | **Жилийн эцэст:** Тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | I улирал | НААХЗА<br><br>ИНҮТ-ийн МТХ | Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.9, 5.10, 5.11 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрлийн олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны e-business.mn сайтад "Иргэний нисэхэд ашиглах аэродром, нисэх буудлын үйлчилгээ", "иргэний агаарын хөлгийн засвар, үйлчилгээ эрхлэх", иргэний агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлээд байна. | 100 |
| | | 4.2.Тус газарт ирүүлсэн гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгоно. | Дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байх. | **Эхний хагас жилд:** Дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байна. | 3 сард | ЗУХЭЗХ | Тус газарт 2023 онд Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй тул дүгнэх боломжгүй. | Үнэлэх боломжгүй |
| | | 4.3. Авлигатай тэмцэх газрын даргын 2019 оны А/40 дүгээр тушаалаар баталсан "Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал"-ын дагуу байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээ | Авлигын эсрэг баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжилт, хувиар. | **Эхний хагас жилд:** Төлөвлөгөөг батлуулсан байна. | 2 сард | ХШҮДАА | Иргэний нисэхийн ерөнхий газрын Авлигын эсрэг баримтлах дунд хугацааны хөтөлбөрийг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/386 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал авахаар харьяа салбар нэгжүүд рүү 2024 оны 5 дугаар срын 08-ны өдрийн 04/1003 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Уг албан бичгийн дагуу ямар нэгэн санал ирүүлээгүй бөгөөд төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хийж боловсруулсан<br><br>Авлигын эсрэг баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангана. | | **Эхний хагас жилд**: 50%<br><br>**Жилийн эцэст:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90%-д хүргэсэн байна. | II-IV улирал | ИНЕГ-ын нэгжүүд<br><br>ИНҮТ-ийн нэгжүүд | Хугацаа болоогүй. | |
| | | 4.4. Үйлчлүүлэгчээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулна. | Бодитой үр дүнг тооцсон байх.<br><br>Тайланд нотлох баримтыг хавсаргасан байх. | **Эхний хагас жилд:** Үйлчлүүлэгчээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгтгэж, санал, дүгнэлт гаргасан байна. | 5 сард | ЗУХЭЗХ | ИНЕГ, түүний харьяа салбар нэгжийн ажилтнуудаас цахимаар 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 07-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 243 албан тушаалтнаас судалгааг авсан. Судалгааны үр дүнд хийсэн тайлан, дүгнэлтийг ИНЕГ-ын даргад 2024.06.21-ний өдөр танилцуулсан бөгөөд АТГ-ын комиссар С.Амартүвшинд и-мэйл хаягаар 2024.06.21-ний өдөр хүргүүлэн ажиллалаа. Авлигатай тэмцэх газрын Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллагууд хариуцсан ажилтан, комиссар С.Амартүвшин нь эхний ээлжинд дотоод ажилтнуудаасаа сэтгэл ханамжийн судалгааг авч, үр дүн, тайланг ирүүл гэсэн чиглэлийн дагуу дээрх арга хэмжээг зохион байгуулан ажилласан болно. | 100 |
| | | | | **Жилийн эцэст:** Судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион | III-IV улирал | НААХЗА<br><br>ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжүүд | Хугацаа болоогүй. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулсан байна. | | | | |
| | | 4.5. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, өмнөх оны үнэлгээг дээшлүүлнэ. | Байгууллагын цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулсан эсэх | **Эхний хагас жилд:** Мэдээллийг 100% байршуулсан байна. **Жилийн эцэст:** Мэдээллийг 100% байршуулсан байна. | 1-11 сард | ЗУХЭЗХ ИНЕГ-ын нэгжүүд | Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар нэгжүүд https://www.mcaa.gov.mn/, https://ncac.mcaa.gov.mn/ сайтыг ажиллуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан дутуу мэдээллүүдийг нийтэд ойлгомжтой байдлаар байршуулж, сар бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Мөн Иргэний нисэхийн ерөнхий газрын цахим хуудас, мэдээллийн самбар дахь үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдалд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 10, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 6, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 28, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 2, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал 25, нийт 71 нээлттэй мэдээллийн тус байгууллагад хамаарах 42 /үүнээс хугацаа болоогүй 3/ мэдээлэлд Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хүснэгт"-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үнэлгээ хийхэд 92.34 хувьтай гарсан. Уг үнэлгээг ИНЕГ-ын даргад 2024.05.30-ны өдөр танилцуулсан. Мөн ИНЕГ-ын харьяа салбар нэгжүүд рүү цахимаар хүргүүлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Байгууллагын удирдлагын түвшнээс авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 5.1. Удирдлагын түвшнээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1 дүгээр улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулна. | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br><br>-Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;<br><br>-Тайланд нотлох баримтыг хавсаргасан байх. | **Эхний хагас жилд:** Төлөвлөгөөг танилцуулсан байна. | 3 сард | ХШҮДАА | ИНЕГ-ын даргын 2024.03.07-ны өдрийн А/146 дугаар тушаалаар "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралтаар баталсан. Уг төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд байршуулсан бөгөөд хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100 |
| | | | | Хэрэгжилтийг явцыг танилцуулсан байна. | 6 сард | ХШҮДАА | | |
| | | | | **Жилийн эцэст:** Хэрэгжилт хүрсэн үр дүнг нийт албан хаагчдадаа танилцуулсан байна. | 11 сард | ХШҮДАА | | |
| | | 5.2. Авлигатай тэмцэх газраас дүрэм, журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байна. | -Санал тусгасан байх;<br><br>-Тайланд нотлох баримтыг хавсаргасан байх. | **Эхний хагас жилд:** Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | ИНЕГ-ын нэгжүүд<br><br>ИНҮТ, харьяа салбар, нэгжүүд | Өнөөдрийн байдлаар ИНЕГ-ын ёс зүйн дүрэмд өөрчлөлт шинэчлэлт хийгдээгүй байна. | Үнэлэх боломж гүй |
| | | 5.3. Шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангана. | Төлөвлөгөөг боловсруулж, АТГ-аар хянуулж батлуулсан эсэх | **Эхний хагас жилд:** Төлөвлөгөөг батлуулсан байна.<br>80%-д хүргэсэн байна. | 2 -6 сард | ХШҮДАА<br><br>ИНЕГ-ын нэгжүүд<br><br>ИНҮТ, | ИНЕГ-ын даргын 2024.03.07-ны өдрийн А/146 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар Шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг баталсан бөгөөд хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар | | | харьяа салбар, нэгжүүд | төлөвлөгөөний хэрэгжилт 83.6 хувьтай байна. | |
| | | | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар | **Жилийн эцэст:** 100%-д хүргэсэн байна. | 7-9 сард | ИНЕГ-ын нэгжүүд<br><br>ИНҮТ | Хугацаа болоогүй | |

Нийт 17 арга хэмжээ төлөвлөснөөс 100 хувьтай -13, 30 хувьтай - 2, үнэлэх боломжгүй - 2 арга хэмжээ байна. Төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 90.7 хувьтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА — Ч.МӨНХТУЯА

ХЯНАСАН:
ЗУХЭЗХ-ИЙН ДАРГА — З.ТУЯА

ХШҮДАА-НЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Л.БАТСҮХ

НЭГТГЭСЭН:
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН — Ө.МАРАЛМАА